

Сангийн сайдын 2020 оны дугаар
сарын-ний өдрийн дүгээр
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

**ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН
БАРАА ХУДАЛДАЖ АВАХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ
БАРИМТ БИЧИГ**

ОРШИЛ

Захиалагч, түүнээс томилогдсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулахдаа харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгөөс давсан бараа (цаашид “бараа” гэх), харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгөөс давсан зөвлөхөөс бусад үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх)-ний тендерийн баримт бичгийг боловсруулах, батлахдаа энэхүү жишиг баримт бичгийг ашиглана.

Тендерийн баримт бичиг бэлтгэж буй этгээд нь тендерийн жишиг баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ) болон гэрээний тусгай нөхцөл (ГТН)-ийн холбогдох заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулах замаар тухайн бараа, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө. Үүнд:

1. Тендерийн баримт бичгийг худалдан авах бараа, үйлчилгээний онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч тендерийн баримт бичгийг бэлтгэхдээ налуу үсгээр, хаалтан дотор бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргийг бөглөнө. Тендерт оролцогчийн бөглөх маягтыг захиалагч бөглөхгүй.
3. Тендерийн жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон бүлэг бүрийн өмнө буй санамж нь тендерийн баримт бичиг бэлтгэж буй этгээдэд заавар өгөх зорилготой бөгөөд тендерийн баримт бичгийг эцэслэн боловсруулахдаа тэдгээрийг хасна.
4. Давхар дөрвөлжин хүрээнд бичигдсэн санамж нь тендерт оролцогчид зориулагдсан тул захиалагч тендерийн баримт бичиг бэлтгэхдээ түүнийг үлдээнэ.
5. Аль нэг нөхцөлийг хэд хэдэн бүлэг, зүйлд давхар заах шаардлагатай бол тэдгээр нь хоорондоо зөрчилдөхгүй байх ёстойг анхаарвал зохино.

Энэхүү тендерийн жишиг баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль эрх зүйн газрын

Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс

Утас: 260206, 267416, 267648

Худалдан авах ажиллагааны цахим систем: www.tender.gov.mn

ЗӨВЛӨХӨӨС БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН БАРАА ХУДАЛДАЖ АВАХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

АГУУЛГА

Бүлэг I. Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа (ТӨӨЗ)

Энэ бүлэг нь тендер бэлтгэх, илгээхтэй холбоотой мэдээллийг тендерт оролцогчид өгнө. Тендер ирүүлэх, тендер нээх, үнэлж шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгохтой холбоотой мэдээлэл, мөн “хамгийн сайн” тендерийг шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал болон тендерт оролцогч тухайн гэрээг гүйцэтгэх чадвартай эсэхийг тогтоох ерөнхий шалгуур үзүүлэлтийг ТӨӨЗ-нд дурдсан байна. Нэгдүгээр бүлэг дэх зүйл, заалтуудыг захиалагч өөрчлөхгүйгээр ашиглана.

Бүлэг II. Тендер шалгаруулалтын өгөгдөлийн хүснэгт (ТШӨХ)

Энэ бүлэг нь тухайн худалдан авах ажиллагаа бүрд тохирсон онцлог заалтуудыг агуулах бөгөөд эдгээр нь нэгдүгээр бүлэг буюу Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа дахь мэдээлэл, шалгуур үзүүлэлтэд захиалагчийн оруулах нэмэлтээс бүрдэнэ.

Бүлэг III. Тендер шалгаруулалтын маягт

Энэ бүлэгт тендер ирүүлэх маягт, үнийн хуваарийн хүснэгт, тендерийн баталгааны маягт болон үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн маягт зэрэг тендерт оролцогчоос өөрийн тендерийн хамт бөглөж ирүүлэх шаардлагатай маягтууд багтана.

Бүлэг IV. Техникийн тодорхойлолт болон бусад шаардлага

Энэ бүлэгт худалдан авах бараа, үйлчилгээний болон түүнийг дагалдах үйлчилгээний жагсаалт, тэдгээрийг захиалагчид хүргэх хуваарь, техникийн тодорхойлолт болон дагалдах үйлчилгээг тайлбарласан, дүрсэлсэн зураг зэрэг мэдээлэл багтана.

Жич: Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн хэсэг, бүлгийн оноосон нэр, гарчиг нь уг баримт бичгийг ойлгоход хялбар дөхөм болгох зорилгоор хэрэглэсэн бөгөөд ямар нэгэн хэм хэмжээ илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.

[ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР]

**[ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАТЛАГДСАН НЭР]-ИЙН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалтын нэр,
дугаар:

.....

ГАРЧИГ

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА.....	8
А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	8
1. Тендерийн цар хүрээ	8
2. Санхүүжилтийн эх үүсвэр	8
3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл	8
4. Эрх бүхий тендерт оролцогч	9
5. Туслан гүйцэтгэгч ба түншлэл.....	10
6. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх	11
7. Эрх бүхий бараа, үйлчилгээ	11
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ	11
8. Тендерийн баримт бичиг	11
9. Тендерийн баримт бичгийг тодруулах.....	12
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	12
11. Тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах.....	12
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ, ИЛГЭЭХ.....	13
12. Тендер шалгаруулалтад оролцох зардал	14
13. Тендерийн хэл.....	14
14. Тендерийн иж бүрдэл	14
15. Гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт.....	15
16. Санал болгож буй бараа, үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт	18
17. Тендер шалгаруулалтын маягт	19
18. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт	20
19. Тендерийн валют	22
20. Тендер хүчинтэй байх хугацаа	22
21. Тендерийн баталгаа.....	23
22. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах	25
23. Хувилбарт тендер	25
24. Тендер илгээх.....	26
25. Тендер илгээх эцсийн хугацаа	26
Г. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ	26
26. Тендерийг нээх.....	27
27. Нууцлах.....	27

28. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох.....	28
29. Тендерийг үнэлэх харьцуулах.....	29
30. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах.....	34
31. Аливаа тендерийг сонгох, эсхүл татгалзах захиалагчийн эрх	34
Д. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ	35
32. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур	35
33. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл	35
34. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх.....	35
35. Гэрээнд гарын үсэг зурах.....	35
36. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол	36
37. Гүйцэтгэлийн баталгаа	36
38. Урьдчилгаа төлбөр.....	37
39. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж буй тендер шалгаруулалт	37
40. Урьдчилсан сонголт явуулах.....	37
41. Мэдээллийн ил тод байдал	38

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Тендерт оролцогчид өгөх зааварчилгааны санамж

Энэ бүлэгт захиалагчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхтэй холбоотойгоор тендерт оролцогчид шаардагдах бүрэн мэдээлэл багтсан. Түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх, “хамгийн сайн” тендерийг шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээлэл тусгагдсан. Энэ бүлэгт тусгагдсан зааварчилгааг захиалагч, тендерт оролцогч чанд мөрдөнө.

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|--|--|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид “ТШӨХ” гэх)-д тодорхойлсон захиалагч нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ, техникийн тодорхойлолтод заасан зөвлөхөөс бусад үйлчилгээ болон бараа, материал, тоног төхөөрөмж (цаашид “бараа, үйлчилгээ” гэх)-г худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна. Чанар, стандартын шаардлага хангасан дотоодын үйлдвэрээс авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь багцална.</p> <p>1.3. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлж болно. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер ирүүлэхийг хориглоно.</p> <p>1.4. Тендерт шалгарсан этгээд техникийн тодорхойлолтод нийцсэн бараа, үйлчилгээг ТШӨХ-д заасан хугацаанд, заасан газарт хүргэж, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | <p>2.1. Захиалагч батлагдсан нийт төсөвт өртөг болон санхүүжүүлэх эх үүсвэрийг ТШӨХ-д бичнэ.</p> |
| 3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл | <p>3.1. Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч болон тендерт оролцогч, гүйцэтгэгч буюу гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан авлига, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад нэн даруй зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.</p> |

4. Эрх бүхий тендерт оролцогч

- 4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрд нээлттэй. Хуулийн 9 дүгээр 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьяалалтай байж болно.
- 4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрд нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
 - 4.2.1. хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасантай адилтгах нөхцөлд байгаа;
 - 4.2.2. энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч/эзэмшигч нь нэг этгээд бол;
 - 4.2.3. энэхүү тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 23-т хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй).
- 4.3. Тендерт оролцогч ТООЗ-ны 4.2.1-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл болон тэдгээрийн талаар холбогдох эрх бүхий байгууллагаас тодруулахад татгалзах зүйлгүй талаар энэ баримт бичгийн 3-р бүлэг дэх маягтын дагуу албан ёсны мэдэгдэл ирүүлнэ.
- 4.4. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.
- 4.5. Тендерт оролцогч ТООЗ-ны 4.2-т дурдсан нөхцөл үүссэн нь тогтоогдвол тухайн тендерт оролцогчийг ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ.

5. Туслан гүйцэтгэгч ба түншлэл

- 5.1. Тендерт оролцогч хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээдтэй туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулж болно.
- 5.2. ТООЗ-ны 5.1-д заасан нийт туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хэмжээ тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.
- 5.3. ТООЗ-ны 5.1-д заасан туслан гүйцэтгэгчийн ирүүлэх нотлох баримтыг ТШӨХ-д заана.
- 5.4. Тендерт оролцогч ТООЗ-ны 5.2-т зааснаас дээш хувийг бусдаар гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерээ “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу ирүүлнэ.
- 5.5. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч (цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх) болж тендер ирүүлэх тохиолдолд талууд тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт болон дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 5.5.1. түншлэлийн гэрээ нь Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байна;
 - 5.5.2. ТООЗ-ны 1.1-д заасан бараа, үйлчилгээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж түншлэлийн гэрээнд тодорхойлсон байх;
 - 5.5.3. түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.
 - 5.5.4. түншлэлийн гишүүн бүр ТООЗ-ны 15-д заасан бүх мэдээллийг тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ.
 - 5.5.5. түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;
 - 5.5.6. нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухай түншлэлийн гэрээгээр зохицуулсан байх;
- 5.6. Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгаагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

- | | |
|---|---|
| 6. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх | 6.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ.
6.2. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.
6.3. Тендер шалгаруулалтад оролцож буй тендерт оролцогчдын хувь эзэмшигчид нэгдмэл сонирхолтой бол тэдгээрийн тендерээс татгалзана. |
| 7. Эрх бүхий бараа, үйлчилгээ | 7.1. Гэрээгээр нийлүүлэх бараа, үйлчилгээ нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТООЗ-ны 1.1-д дурдсан бараа, үйлчилгээг хүлээн авснаар төлнө.
7.2. Эрх бүхий бараа гэдэг нь захиалагчийн тавьсан шалгуурыг бүрэн хангасан барааг хэлнэ. |

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

- | | |
|---------------------------|--|
| 8. Тендерийн баримт бичиг | 8.1. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй.
8.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж захиалагчаар батлуулна.
8.3. Тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-р зохион байгуулна.
8.4. Тендерийн урилгыг тендерийн баримт бичигт нийцүүлэн системд нийтэлнэ. |
|---------------------------|--|

- | | |
|--|---|
| 9. Тендерийн баримт бичгийг тодруулах | <p>9.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ цахим системээр гаргана.</p> <p>9.2. ТООЗ-ны 9.1-д илгээсэн тодруулгыг тендерт оролцохыг сонирхогч этгээд албан бичгээр баталгаажуулж ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар хүргүүлнэ.</p> <p>9.3. Тендерт оролцогч ТООЗ-ны 9.1-д заасан тодруулга авах хүсэлтийг ТООЗ-ны 25.1-д заасан хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гаргана.</p> <p>9.4. ТООЗ-ны 9.3-н дагуу ирүүлсэн тодруулгын хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр цахим системд нийтэлснээр хариу тодруулга, нэмэлт мэдээллийг хүргүүлсэнд тооцно.</p> <p>9.5. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТООЗ-ны 11 болон 25.2-т заасан журмыг баримтална.</p> |
| 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт | <p>10.1. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах талаар ТШӨХ-д заасан бол тендерт оролцохыг сонирхогч этгээдээс томилсон төлөөлөгчийг түүнд урьж оролцуулна. Уг уулзалт нь тендер бэлтгэх явцад үүсэж болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар тендерт оролцохыг сонирхогч этгээдийн тавьсан асуултад хариулт өгөх зорилготой.</p> <p>10.2. Тендерийн өмнөх уулзалтад оролцоогүй нь тендерт оролцохыг сонирхогч этгээдийн тендерт оролцох эрхийг хязгаарлахгүй.</p> <p>10.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш болон гэрээ байгуулах эрх олгохоос өмнө ямар нэгэн уулзалт зохион байгуулахгүй.</p> |
| 11. Тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах | <p>11.1. Захиалагч ТООЗ-ны 25.1-д заасан хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>11.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд системд нийтэлснээр тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд мэдээлсэнд тооцно.</p> <p>11.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцохыг сонирхогч этгээдэд олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч ТООЗ-ны 25.1-д заасан тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгана.</p> |

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ, ИЛГЭЭХ

- | | |
|--|--|
| 12. Тендер
шалгаруулалтад
оролцох зардал | <p>12.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, илгээхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд тендер шалгаруулалтын явц, дүнгээс үл хамааран энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.</p> <p>12.2. Тендерт оролцохыг сонирхогч этгээд тухайн бараа, үйлчилгээ хүргэх газар, орчны нөхцөл байдалтай танилцаж болох бөгөөд түүнтэй холбогдон гарах зардлыг өөрөө хариуцна.</p> |
| 13. Тендерийн хэл | <p>13.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотой асуудлаар захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг ТООЗ-ны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна.</p> <p>13.2. Тендерийн баримт бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн тендерийн баримт бичгийн заалтыг баримтална.</p> <p>13.3. Аливаа тендерийн дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТООЗ-ны 13.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.</p> |
| 14. Тендерийн иж бүрдэл | <p>14.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>14.1.1. ТООЗ-ны 17-д заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт, үнийн болон үйлчилгээний хуваарь;</p> <p>14.1.2. Захиалагч шаардсан бол ТООЗ-ны 21-д заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;</p> <p>14.1.3. тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий эсэхийг нотлоход шаардлагатай ТООЗ-ны 15-д заасан баримтууд;</p> <p>14.1.4. нийлүүлэх бараа, үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТООЗ-ны 16-д заасан нотлох баримт;</p> |

14. Гэрээ хэрэгжүүлэх
чадварыг нотлох
баримт

14.1. Тендерт оролцогч нь хуулийн 14 дүгээр зүйлд заасан ерөнхий нөхцөлийг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

- 14.1.1. хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 14.1.2. тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл;
- 14.1.3. ТШӨХ-д шаардсан бол тухайн бараа, үйлчилгээний хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл;
- 14.1.4. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн байх-цахим системээс;
- 14.1.5. сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргийн биелэлтийн талаарх Шүүхийн төрөлжсөн архивын лавлагааг одоогийн ба сүүлийн 3 хүртэлх жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;

14.2. Тендерт оролцогч нь хуулийн 15 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлтийг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

- 14.2.1. санхүүгийн чадавхыг харуулах ТШӨХ-д заасан жилийн санхүүгийн тайлан-цахим системээс.
- 14.2.2. харилцагч банкны өр зээлгүй тухай мэдэгдэл;
- 14.2.3. сүүлийн 5 хүртэлх жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн (гэрээт ажлын гүйцэтгэл 90 ба түүнээс дээш хувь байх) борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;
- 14.2.4. түншлэлийн гишүүн тус бүр ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.
- 14.2.5. бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах

боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.

- 14.3. Тендерт оролцогч түншлэл нь ТООЗ-ны 15.2.3 ба 15.2.5-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ түншлэлийн гишүүн тус бүр ТООЗ-ны 15.2.3, 15.2.5-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байх шаардлагатай.
- 14.4. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.
- 14.5. Түншлэл нь ТООЗ-ны 15.2.3, 15.2.5-д заасан шалгуур үзүүлэлтийг түншлэлийн тооноос үл хамааран дээрх шалгуур үзүүлэлтийг 100 хувь хангасан байна.
- 14.6. Тендерт оролцогч нь хуулийн 16 дугаар зүйлд заасан техникийн чадавх болон туршлагыг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:
 - 14.6.1. хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан ёсны зөвшөөрлийг 3-р бүлэгт заасан маягтын дагуу ирүүлнэ. Нийлүүлэгчийн хуваарьт заасан гарал үүслийн улс, үйлдвэрлэгчийн хаяг зөрвөл татгалзах үндэслэл болно;
 - 14.6.2. гэрээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх ТШӨХ-д шаардсан мэдээлэл;
 - 14.6.3. тендерт оролцогчийн туршлагыг харуулах ТШӨХ-д заасан 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл болон одоо хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний

- талаарх мэдээллийг 3-р бүлэгт заасан маягтын дагуу ирүүлэх;
- 14.6.4. хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
- 14.6.5. гэрээг гүйцэтгэхэд ашиглагдах ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл болон цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
- 14.7. Тендерт оролцогч ТООЗ-ны 15.6.3 ба 15.6.5-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.
- 14.8. Тендерт оролцогч ТООЗ-ны 15-д заасан материалаас цахим системтэй холбогдсон баримт бичиг (санхүүгийн тайлан, татварын албаны тодорхойлолт гэх мэт)-ийг ирүүлэх шаардлагагүй бөгөөд үнэлгээний хороо тендерийн нээлт хийсэн өдөр мэдээллийн баазаас дамжуулсан мэдээллийг үндэслэл болгон үнэлгээ хийнэ.
- 14.9. Захиалагч гэрээ хэрэгжүүлэх чадвартайг нотлох нэмэлт баримтыг ТШӨХ-д зааж болно.

15. Санал болгож буй бараа, үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт

15.1. Тендерт оролцогч, түүний санал болгож буй бараа, үйлчилгээ нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:

15.1.1. техникийн болон үйл ажиллагаа, үйлчилгээний шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;

15.1.2. барааны хувьд ТШӨХ-д заасан хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт ирүүлнэ. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;

15.1.3. санал болгож буй бараа, үйлчилгээ нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон, мэргэжлийн байгууллагаас гаргасан мэдэгдэл;

15.1.4. техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч нэмэлт тайлбар ирүүлж болно.

15.2. Тендерт өөр стандарт, тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн болон үйлчилгээний тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.

15.3. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлт болон нотлох баримт, материалыг тендертэй хамт ирүүлнэ.

17. Тендер
шалгаруулалтын
маягт

17.1. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн 3-р бүлэгт заасан маягтыг ирүүлнэ. Маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.

18. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт

- 18.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд:
- 18.1.1. үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.
 - 18.1.2. тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.
 - 18.1.3. тендерт оролцогч хоёр ба түүнээс дээш багцад санал хүргүүлж шалгарах тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт санал болгож болно.
 - 18.1.4. тендерт оролцогч нь аливаа үнийн хөнгөлөлт болон нөхцөлт үнийн хөнгөлөлтийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.
 - 18.1.5. олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.
 - 18.1.6. бараа, үйлчилгээний үнийг 3-р бүлэгт заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээнд заасан бараа, үйлчилгээний нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, гарал үүслийн улсын нэрийг нийлүүлэлтийн болон үйлчилгээний хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 18.2. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.
- 18.3. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан заасан тохиолдолд үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг ТШӨХ-д тусгана.
- 18.4. ТООЗ-ны 18.3-т зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна.

- 18.5. Тендерийн үнийг тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 28-д заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.
- 18.6. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

- | | |
|----------------------------------|---|
| 19. Тендерийн валют | 19.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна. |
| 20. Тендер хүчинтэй байх хугацаа | <p>20.1. Тендерт оролцогчийн тендерийн маягт дээрх тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино эсхүл хүчинтэй хугацааг бөглөж ирүүлээгүй тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.</p> <p>20.2. Хуульд заасны дагуу тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх оролцогчдод хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлт тавина. Энэхүү хүсэлт болон түүний хариуг бичгээр болон системээр мэдэгдэнэ. Хэрэв тендерт оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг зөвшөөрвөл тендерийн баталгааны хугацааг мөн адил сунгаж ирүүлнэ. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогчоос тендерээ өөрчлөхийг зөвшөөрөх эсхүл шаардахыг хориглох боловч тендерийн баталгааны хүчинтэй хугацааг ТООЗ-ны 21-д нийцүүлэн сунгахыг шаардаж болно.</p> <p>20.3. Тендерт оролцогч тендерийн баталгаагаа үл гүйцэтгүүлэн өөрийн тендер хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзах эрхтэй.</p> |

21. Тендерийн баталгаа

- 21.1. ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.
- 21.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол багц тус бүрээр тендерийн баталгаа ирүүлнэ.
- 21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.
- 21.4. Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг 3-р бүлэг дэх маягтаар ирүүлнэ.
- 21.5. Тендерт оролцогч тендерийн баталгааг тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног буюу захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.
- 21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- 21.7. Захиалагч шалгарсан этгээдтэй гэрээ байгуулсны дараа бүх оролцогчийн тендерийн баталгааг чөлөөлнө.
- 21.8. Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг ТООЗ-ны 35-д заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТООЗ-ны 37-д заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.
- 21.9. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:
 - 21.9.1. тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч тендер шалгаруулалтад оролцохоос татгалзсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
 - 21.9.2. тендерт оролцогч ТООЗ-ны 32.2-т заасны дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТООЗ-ны 39.2-т заасан нөхцөл үүссэн бол;
 - 21.9.3. шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан ТООЗ-ны 42-т заасны дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;
 - 21.9.4. ТООЗ-ны 44-т заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй.
 - 21.9.5. тендерт оролцогчийн гаргасан гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
- 21.10. Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй

аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

22. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах

- 22.1. Тендерт оролцохыг сонирхогч этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах тухай системээр дамжуулан гаргаж болно.
- 22.2. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.
- 22.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь ТООЗ-ны 22-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно. Тендерт оролцогч илгээсэн тендерээ тендерийн нээлтээс хойш буцаах хүсэлтэй бол энэ тухай захиалагчид албан бичгээр мэдэгдэнэ.

23. Хувилбарт тендер

- 23.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.
- 23.2. Хэрэв ТШӨХ-д зөвшөөрсөн бол тендерийн баримт бичгийн шаардлагаас өөр хувилбартай техникийн санал гаргах хүсэлтэй тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлага, түүний дотор техникийн болон үйлчилгээний тодорхойлолтод заасан шаардлагад нийцсэн үндсэн тендер ирүүлэх ёстой. Тендерт оролцогч үндсэн тендер ирүүлэхийн зэрэгцээ хувилбарт тендерт бүрэн үнэлгээ хийхийн тулд захиалагчид шаардагдах бүх мэдээлэл, түүний дотор техникийн болон үйлчилгээний тодорхойлолт, үнийн задаргаа болон бусад холбогдох мэдээллийг ирүүлнэ. Зөвхөн үндсэн тендер нь “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн, техникийн үндсэн шаардлагыг хангасан тендерт оролцогчийн хувилбарт тендерийг захиалагч авч үзнэ. Хувилбарт тендерийг үндсэн тендерээс тусад нь системд оруулж баталгаажуулна.
- 23.3. Хэрэв үйлчилгээний тодорхой хэсгийг хувилбар бүхий техникийн шийдэлтэйгээр ирүүлэхийг ТШӨХ-д зөвшөөрсөн бол үүнийг үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтод тусгасан байвал зохино. Энэ тохиолдолд дээрх хувилбарт тендерийг үнэлэх аргыг ТШӨХ-д мөн адил тусгана.

24. Тендер илгээх
- 24.1. Тендерт оролцогч тендерээ цахим системээр өөрийн байгууллагын хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч электрон хэлбэр /Adobe PDF/-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb-аас ихгүй, нэг файлын хэмжээ 15 Mb-аас ихгүй байна.
- 24.2. “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу тендерт оролцох хураамжийг банкны меркантийн системийг ашиглан төлнө.
- 24.3. Тендерт оролцогч эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох тендерийн баримт бичгийн 3-р бүлэг дэх маягтууд болон захиалагчийн ТШӨХ-ийн 24.3-т заасан материалыг нууцлахгүй ирүүлэх ёстой.
- 24.4. ТООЗ-ны 17.3-т заасан материалаас Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь илгээх бөгөөд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.
25. Тендер илгээх эцсийн хугацаа
- 25.1. Тендерт оролцогч ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө цахим системээр тендер илгээнэ.
- 25.2. Захиалагч ТООЗ-ны 10-т заасны дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

Г. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ

26. Тендерийг нээх

- 26.1. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр дамжуулан ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан газарт зохион байгуулна.
- 26.2. ТШӨХ-д заасан газар зохион байгуулж буй тендерийн нээлтэд тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.
- 26.3. Тендерийг нээх үед дараах мэдээллийг системээр зарлаж, баталгаажуулна. Үүнд:
 - 26.3.1. тендерт оролцогчийн нэр;
 - 26.3.2. тендерийн үнэ;
 - 26.3.3. санал болгосон бол үнийн хөнгөлөлт;
 - 26.3.4. хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ;
 - 26.3.5. тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;
 - 26.3.6. захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 26.4. Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед дээрх мэдээллийг багц тус бүрээр мэдээлнэ.
- 26.5. Тендер нээх үед цахим системээр ирүүлээгүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

27. Нууцлах

- 27.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 27.2. Тендер шалгаруулалттай холбоотой аливаа асуудлаар тендерт оролцогч болон захиалагч зөвхөн албан бичгээр харилцана.

28. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох
- 28.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараах шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:
- 28.1.1. ТООЗ-ны 4-т заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
 - 28.1.2. тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;
 - 28.1.3. зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагыг хангасан тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;
 - 28.1.4. тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх
 - 28.1.5. тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх.
- 28.2. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл шаардлагыг хангаж байгаа, тендерт оролцогчийн санал болгосон бараа, үйлчилгээ нь ТООЗ-ны 20-д заасан нөхцөл болон тодорхойлолтыг томоохон зөрүүгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг томоохон зөрүү гэж үзнэ. Үүнд:
- 28.2.1. тендерт санал болгож буй бараа, үйлчилгээ нь тодорхойлолт болон гэрээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
 - 28.2.2. гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
 - 28.2.3. зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

29. Тендерийг үнэлэх
харьцуулах

- 29.1. Захиалагч зөвхөн ТООЗ-ны 42-д заасан шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.
- 29.2. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдолд ТООЗ-ны 18-д зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд тендерийг үнэлэх, харьцуулахдаа тендер зарласан өдрийн Монгол банкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.
- 29.3. Захиалагч шаардлагад нийцсэн гэж үнэлсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:
 - 29.3.1. тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоон дүнг залруулах;
 - 29.3.2. нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;
 - 29.3.3. нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 29.4. Захиалагч тендерийн үнэд ТООЗ-ны 29.3-н дагуу залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.
- 29.5. Захиалагч шаардлагад нийцсэн гэж үнэлсэн тендерт оролцогчийн санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцож үнэлгээнд харгалзан үзнэ.
- 29.6. Захиалагч тендерийг үнэлэхдээ ТООЗ-ны 29.3-т заасны дагуу тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно.
- 29.7. ТООЗ-ны 1.2-т заасан төсөвт өртгөөс үндэслэлгүй хэт бага үнэ ирүүлсэн тендерийг шаардлага хангаагүй гэж үнэлнэ. /Аргачлал оруулах эсэх/

- 29.8. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 70 оноо (S_{max}) өгч, бусад тендерт оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараах томъёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

P_{min} —Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн үнэ

P_x – Тухайн тендерт оролцогчийн үнэ

S_x – Тухайн тендерт оролцогчийн оноо

S_{max} —Хамгийн бага харьцуулах үнэтэй тендер оролцогчийн оноо

- 29.9. Чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

29.9.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

29.9.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй бол (SRA):

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

29.9.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

29.9.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

- 70 ≤ 80 % - 3 оноо;
- 80 ≤ 90 % - 4 оноо;
- 90 ≤ 100% - 5 оноо;

29.9.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт оролцогч үйлдвэрлэдэг бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо;

29.9.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд тендерт оролцогч импортолдог бол:

- Тухайн багцын:
- 0 ≤ 50% - 0 оноо;
 - 50 ≤ 60% - 1 оноо;
 - 60 ≤ 70% - 2 оноо;
 - 70 ≤ 80 % - 3 оноо;
 - 80 ≤ 90 % - 4 оноо;
 - 90 ≤ 100% - 5 оноо;

29.10. Дотоодын үйлдвэрлэгч ТӨӨЗ-ны 29.9.2, 29.9.3-т заасан гэрчилгээтэй гэж үзэн харгалзах оноог өгнө.

29.11. Чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноог ТӨӨЗ-ны 29.8, 29.9-д заасны дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

$$B_x = Q_x + S_x$$

B_x – Тухайн тендерт оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Q_x – Тухайн тендерт оролцогчийн чанарын үнэлгээний оноо

29.12. Хэрэв тендер шалгаруулалтыг ТӨӨЗ-ны 1.2-ын дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:

29.12.1. багц тус бүрд ТӨӨЗ-ны 29-д заасны дагуу тендерийн үнэлгээг хийж, харьцуулах хамгийн бага үнэтэй тендерийг тодорхойлох;

29.12.2. хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерт уг нөхцөлт үнийн хөнгөлөлтийг тооцох;

- 29.12.3. дээрх үнэлгээг хийсний дараа захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсвэл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох;
- 29.13. ТООЗ-ны 23.1-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзан үзнэ.
- 29.14. ТООЗ-ны 29.13-т заасан хувилбарт тендерийг үнэлэхдээ үндсэн тендерийг үнэлсэн зарчмын дагуу шаардлага хангасан эсэхийг үнэлнэ.
- 29.15. ТООЗ-ны 28.2-т заасан томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийнэ.
- 29.16. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсэж болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна. Гэхдээ ТООЗ-ны 32-т заасны дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон ТООЗ-ны 12, 13-т заасан агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.
- 29.17. ТООЗ-ны 16.3-т заасан давуу эрхийн зөрүүг “Давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно.
- 29.18. Захиалагч хуулийн 10 дугаар зүйл болон 10¹ дүгээр зүйлд тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа давуу эрхийн зөрүү тооцохгүй.
- 29.19. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.7.3 дахь хэсэгт заасны дагуу тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно.
- 29.20. Тендер шалгаруулалтын үнэлгээг “Тендерийн үнэлгээний заавар”-ын дагуу хийнэ.
- 29.21. Хэрэв тендер шалгаруулалтыг ТООЗ-ны 1.3-ийн дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:
- 29.21.1. багц тус бүрд ТООЗ-ны 35-д заасны дагуу тендерийн үнэлгээг хийж, харьцуулах хамгийн бага үнэтэй тендерийг тодорхойлох;

- 29.21.2. хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерт уг нөхцөлт үнийн хөнгөлөлтийг тооцох;
- 29.21.3. дээрх үнэлгээг хийсний дараа захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсвэл бүх бацгад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох;
- 29.22. ТООЗ-ны 16.2-т заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзан үзнэ
- 29.23. ТООЗ-ны 32.9-д заасан хувилбарт тендерийг үнэлэхдээ үндсэн тендерийг үнэлсэн зарчмын дагуу шаардлага хангасан эсэхийг үнэлнэ.

- | | |
|--|--|
| <p>30. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах</p> | <p>30.1. Захиалагч шаардлагад нийцсэн, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлан болно.</p> <p>30.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 19.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 31-ийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТООЗ-ны 19.2-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч ТООЗ-ны 19.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.</p> <p>30.3. Нэг тендерт оролцогчид хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тухайн этгээд гэрээг хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангаж буй эсэхийг дахин магадална. Хэрэв чадварын шаардлага хангахгүй бол тухайн этгээдэд гэрээ хэрэгжүүлэх чадварт нь тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.</p> <p>30.4. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин хянан үзээд, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан удаах “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар хянан үзнэ.</p> |
| <p>31. Аливаа тендерийг сонгох, эсхүл татгалзах захиалагчийн эрх</p> | <p>31.1. Захиалагч аливаа тендерийг хүлээн зөвшөөрөх эсхүл татгалзах, мөн тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, гэрээ байгуулах эрх олгохоос өмнөх аль нэг хугацаанд бүх тендерээс татгалзах эрхтэй бөгөөд үүнтэй холбоотойгоор тендерт оролцогчдын өмнө ямарваа нэг хариуцлага хүлээхгүй.</p> <p>31.2. Захиалагч тендер шалгаруулалтыг хүчингүй болгох тохиолдолд үндэслэлийг тодорхой заана.</p> <p>31.3. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.</p> <p>31.4. Тендерт оролцогчийн зүгээс захиалагчид тендерийн үнэлгээний явцад болон гэрээ байгуулах эрх олгоход нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.</p> |

Д. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

- | | |
|---|--|
| 32. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур | <p>32.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд ТООЗ-ны 39-д заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.</p> <p>32.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 32-т заасны дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл бичгээр хариу ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд ТООЗ-ны 22.9-д заасны дагуу түүний тендерийн баталгааг улсын орлого болгоно.</p> |
| 33. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл | <p>33.1. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох шийдвэр болон шалгараагүй тухай мэдэгдлийг тендерийн баримт бичгийн 3-р бүлэг дэх маягтын дагуу тендерт оролцогч нарт нэгэн зэрэг цахим систем болон албан бичгээр мэдэгдэнэ.</p> <p>33.2. Хэрэв гэрээ байгуулах эрх олгосны дараа ажлын 5 хоногийн дотор тендер шалгаруулалтад гомдол гарсан тохиолдолд захиалагч бүх тендерт оролцогчид энэ тухай мэдэгдэнэ.</p> <p>33.3. Гэрээ албан ёсоор хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь талуудын хооронд байгуулсан хэлцэл болно.</p> <p>33.4. Тендер нь шалгарсан оролцогч ТООЗ-ны 44-т заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа гаргаж, гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ.</p> |
| 34. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх | <p>34.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн бараа, үйлчилгээний хэмжээг ТШӨХ-д заасан хувиар өөрчилж болно.</p> |
| 35. Гэрээнд гарын үсэг зурах | <p>35.1. Захиалагч гэрээний маягтыг гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.</p> <p>35.2. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6 хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээнд гарын үсэг зурна.</p> <p>35.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТООЗ-ны 40-д нийцүүлэн тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.</p> |

36. Тендер
шалгаруулалттай
холбоотой гомдол

36.1. Захиалагч тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзвэл тендерт оролцогч гомдлоо “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу нотлох баримтын хамт дараах байгууллагад гаргана. Үүнд:

36.1.1. захиалагч тендерийн баримт бичиг бэлтгэхдээ өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гаргасан гэж үзвэл Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт;

36.1.2. тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзвэл ТООЗ-ны 1.1-д заасан этгээдэд;

36.1.3. ТООЗ-ны 40.1.2-н шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсэгт заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад.

36.2. Тендерт оролцогч ТООЗ-ны 40.1-д заасан гомдлыг дараах хугацаанд гаргана. Үүнд:

36.2.1. ТООЗ-ны 40.1.1-д заасан гомдлыг ТООЗ-ны 26.1-д заасан хугацаанаас ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө;

36.2.2. ТООЗ-ны 40.1.2-т заасан гомдлыг тендерт оролцогч зөрчлийг мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор;

36.2.3. ТООЗ-ны 40.1.3-т заасан гомдлыг ажлын 5 өдрийн дотор.

36.3. Тендерт оролцогч гомдлоосоо ТООЗ-ны 40.1-ийн дагуу эцэслэн шийдвэрлэхээс өмнө татгалзаж болно.

37. Гүйцэтгэлийн
баталгаа

37.1. ТШӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ирүүлнэ.

37.2. Захиалагч шалгарсан оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТООЗ-ны 44.2-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

37.3. Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ны 44.2-т заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

37.4. Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг захиалагч улсын орлого болгоно.

- | | |
|--|--|
| 38. Урьдчилгаа төлбөр | <p>38.1. Захиалагч бэлтгэл хангахад зориулан урьдчилгаа төлбөр төлж болно.</p> <p>38.2. ТШӨХ-д заагаагүй тохиолдолд урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>38.3. Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнг ТШӨХ-д заах бөгөөд шалгарсан этгээд тендерийн баримт бичгийн 3-р бүлэгт заасан маягтын дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлнэ.</p> |
| 39. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж буй тендер шалгаруулалт | <p>39.1. ТООЗ-ны 1.1-д заасан худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТШӨХ-д бичнэ.</p> <p>39.2. Захиалагч ТООЗ-ны 46.1-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бол “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-ыг мөрдлөг болно.</p> <p>39.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны үед тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахыг хориглоно.</p> <p>39.4. Санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, мөн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг өөрчилж баталсан нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар худалдан авах боломжгүй болсон, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилсөн, бууруулсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчдод мэдэгдэнэ.</p> <p>39.5. Гэрээ байгуулаагүйтэй холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч өөрөө хариуцна.</p> <p>39.6. Тендерийн хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын санхүүжилт батлагдсан тохиолдолд тухайн тендер шалгаруулалтыг хүчинтэйд тооцно.</p> |
| 40. Урьдчилсан сонголт явуулах | <p>40.1. Захиалагч төсөвт өртөг өндөр, техникийн хувьд нарийн төвөгтэй, цогцолбор ажлын гүйцэтгэгчийг сонгох дотоодын болон олон улсын тендер шалгаруулалтад оролцох гүйцэтгэгчийн чадавхыг магадлах зорилгоор хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу урьдчилсан сонголт явуулж болно.</p> |

41. Мэдээллийн ил тод байдал

- 41.1. Шалгарсан тендерт оролцогчийн ТООЗ-ны 48.1-д заасан материалыг гэрээ байгуулах эрх олгосон өдрөөс эхлэн тухайн тендер шалгаруулалтад оролцсон бусад тендерт оролцогч танилцах боломжтой байхаар цахим системд ажлын 5 өдөр байршуулна.
- 41.2. Тендер шалгаруулалтад оролцсон этгээд дараах баримт бичиг, материалтай захиалагчид хүсэлт гаргасны үндсэн дээр танилцаж болно. Үүнд:
 - 41.2.1. нээлттэй тендер шалгаруулалтаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл;
 - 41.2.2. тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж;
 - 41.2.3. тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл;
 - 41.2.4. гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ.
- 41.3. Захиалагч цахим системд дараах мэдээллийг ил тод нийтэлнэ. Үүнд:
 - 41.3.1. тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 41.3.2. тендерийн нээлтийн үед зарлагдсан үнийн санал;
 - 41.3.3. шалгараагүй тендерт оролцогчийн нэр, тендерээс татгалзсан шалтгаан;
 - 41.3.4. шалгарсан оролцогчийн нэр, гэрээний үнийн дүн.
- 41.4. ТООЗ-ны 48.4, 48.5-д заасан мэдээллийг гэрээ байгуулах эрх олгосон өдөрт багтааж багц тус бүрээр цахим системд нийтэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт бэлтгэх санамж

Захиалагч шаардлагад нийцсэн тендер хүлээж авахад шаардлагатай мэдээллийг энэ бүлэгт тусгана.

Худалдан авах бараа, үйлчилгээний талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа (ТООЗ)-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Тендерт оролцогч нэгдүгээр бүлгийн ТООЗ-ны зүйл, заалт болон дараах мэдээллийг баримтлан тендерээ бэлтгэнэ.

Тухайн шалгуур үзүүлэлтийг холбогдох бусад салбарын хууль тогтоомжийн хүрээнд хангаж буй тохиолдолд уг бүлэгт тэдгээр шаардлагыг хангах шалгуур үзүүлэлтийг давтан тусгах шаардлагагүй.

Тухайлбал, тусгай зөвшөөрөл, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан...

Захиалагч тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийг бөглөхдөө налуу үсгээр, хаалт дотор бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргийг бөглөх бөгөөд хүснэгтэн доторх бусад мэдээллийг өөрчлөх, устгахыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: [Захиалагчийн нэр, хаягийг бүрэн оруул]
ТӨӨЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр болон дугаар: [тендер шалгаруулалтын нэр, дугаарыг оруул]
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ¹ Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа: <i>[Багц 1: багцад хамаарах бараа, үйлчилгээ Багц 2: багцад хамаарах бараа, үйлчилгээ]</i> Бусад: <i>[Багц 1: багцад хамаарах бараа, үйлчилгээ Багц 2: багцад хамаарах бараа, үйлчилгээ]</i>
ТӨӨЗ 1.4	Гэрээ гүйцэтгэж дуусах хугацаа: [Гэрээт ажлыг гүйцэтгэж дуусгахаар захиалагчийн төлөвлөж буй хугацааг оруул]
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: [эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг оруул²] Батлагдсан төсөвт өртөг: [мөнгөн дүн бичих]
	Б. Тендерийн баримт бичиг
ТӨӨЗ 5.3	Туслан гүйцэтгэгч дараах материалыг ирүүлнэ. Үүнд: 1. <i>Хамтран ажиллах гэрээ</i> 2. <i>Тусгай зөвшөөрөл</i> 3. ...
ТӨӨЗ 9.2	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:

¹ Засгийн газраас баталсан дотоодын үйлдвэрээс авах барааг импортын бараанаас тусад нь багцлах.

² Жишээ нь: Улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсвэл зээлийн хөрөнгийн эх үүсвэр г.м –ийг тодорхой бичнэ.

	<i>[тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг, холбоо барих буюу хариуцсан албан тушаалтны нэр, утасны дугаар, цахим шуудан]</i>
ТӨӨЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <i>[“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож оруул].</i> <i>“Тийм” бол уулзалт болох газар:.....</i> <i>хугацаа:.....</i>
	В. Тендер бэлтгэх, илгээх
ТӨӨЗ 13.1	Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэлээс гадна дараах хэл дээр байна. Үүнд: <i>[олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг гадаад хэлнээс захиалагч сонгож оруулна. Жишээлбэл, “Англи хэл” эсхүл “Франц хэл” эсхүл “Испани хэл” г.м].</i> <i>Тендерт оролцогчид дээр тодорхойлсон Монгол хэл болон захиалагчийн сонгосон гадаад хэлний аль нэгийг сонгож тендерээ уг сонгосон хэл дээр бэлтгэж ирүүлэх бөгөөд нэгээс дээш хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлэхийг хориглоно. Шалгарсан тендерт оролцогчтой байгуулах гэрээг түүний тендериүүлсэн хэл дээр байгуулна.</i>
ТӨӨЗ 15.1	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: 1. 2. <i>[шаардлагатай баримт бичгүүдийг жагсааж бичих]</i>
ТӨӨЗ 16.1	Хувилбарт тендер ирүүлэхийг <i>[“зөвшөөрнө” эсхүл “зөвшөөрөхгүй” гэдгээс аль нэгийг сонгож оруул].</i>
ТӨӨЗ 23.1	Хувилбарт тендер үнэлэх аргачлал: <i>[...]</i>
ТӨӨЗ 18.1.5	Олон улсын худалдааны Инкотермс -ийн хувилбар: <i>[хэвлэгдсэн оныг нь оруул. Жишээ нь: “Incoterms 2010”].</i> Бараа хүргэгдэх газар: <i>[бараа хүргэгдэх байршлыг оруул.]</i> <i>“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”</i> : <i>[захиалагч барааг хүлээн авах агуулах, эсвэл уг бараа ашиглагдах газрын байршилыг оруул]</i>

ТОӨЗ 18.3	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад ["тохируулж болно." эсхүл "тохируулахгүй тогтмол байна." гэснээс аль тохирохыг сонгож үлдээ.]³ <i>Хэрэв гэрээний үнийг тохируулах бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг захиалагч тендер зарлахаас өмнө урьдчилан тогтоож, 6 дугаар бүлэгт заасан гэрээний нөхцөлд тусгана.</i>
ТОӨЗ 11.1	Тендерийн валют: [Төгрөг байна.]
ТОӨЗ 15.1.3	Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: ["тийм" эсхүл "үгүй" гэдгээс аль нэгийг сонгож оруул]. "тийм" бол тусгай зөвшөөрлийн нэр:.....
ТОӨЗ 15.2.3	Борлуулалтын хэмжээ: [мөнгөн дүн/хувь хэмжээгээр тусгах]
ТОӨЗ 15.2.4	Ашигтай ажилласан байх жилийн тоо: [жилийн тоог оруул]
ТОӨЗ 15.2.5	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: [захиалагчаас шаардаж буй түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг оруул]
ТОӨЗ 15.6.1	Үйлдвэрлэгч эсвэл гэрээт борлуулагчийн албан ёсны зөвшөөрөл: ["шаардлагатай" эсхүл "шаардлагагүй" гэж оруул.
ТОӨЗ 15.6.3	Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: [жишээ: Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны аль нэг жилд нь ядаж нэг удаа төсөвт өртгийн 30 хувьтай тэнцүү ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна. Гэрээний хуулбар, ажил хүлээлгэн өгсөн комиссын актын хуулбарыг хавсаргана.]
ТОӨЗ 21.1	Тендерийн баталгааны үнийн дүн: Багц 1: Багц 2: /гэх мэтчилэн/ [Төсөвт өргийн 1-2 хувиар баталгааны хэмжээг тогтоож үнийн дүнг оруулна.] Хүчинтэй байх хугацаа: он сар өдөр

³ Захиалагч 2 жилээс дээш хугацаагаар хэрэгжих, эсхүл суурь үнэ огцом өөрчлөгдсөн нөхцөлд гэрээний үнэд тохируулга хийж болохоор хуулийн 40.4 дэх хэсэгт зохицуулсан.

	<i>[Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацааг он, сар, өдрөөр тогтооно.]</i>
ТӨӨЗ 15.8	Тендерийн нээлт хийсэн өдөр цахим системээр дамжуулан татан авч үнэлгээ хийх баримт бичгийн жагсаалт: 1. <i>Татварын тодорхойлолт</i> 2. <i>Санхүүгийн тайлан</i> 3. ...
ТӨӨЗ 23.1	Хувилбарт тендер ирүүлэхийг <i>["зөвшөөрнө" эсхүл "зөвшөөрөхгүй" гэдгээс аль нэгийг сонгож оруул.]</i> <i>[Хэрэв хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн бол дараах бичвэрийг оруул:</i> <i>"Тендерт лийг биелүүлсэн хувилбарт тендерийг үндсэн тендерийн хамт ирүүлж болно. Гэвч зөвхөн хамгийн сайн үнэлэгдсэн үндсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийн хувилбарт тендерийг захиалагч харгалзан үзнэ."]</i>
ТӨӨЗ 24.3	Гуравдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: 1. <i>[Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлох баримт бичгийг жагсаан бичих]</i> 2. ... 3. ...
ТӨӨЗ 25.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <i>[он, сар, өдрийг оруул. Жишээ нь: 2020 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр]</i> Цаг: <i>[цаг, минутыг тодорхой оруул. Жишээ нь: 15 цаг 30 минут г.м]</i>
ТӨӨЗ 26.1	Тендерийн нээлтийг цахим системээр хийх бөгөөд сонирхсон этгээд дараах газар ирж нээлтийн үйл ажиллагаатай танилцаж болно. Тендерийн нээлт хийх газрын хаяг: <i>[аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</i> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>[он, сар, өдрийг оруул. Жишээ нь: 2020 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр]</i>

	Цаг: <i>[цаг, минутыг тодорхой оруул. Жишээ нь: 16 цаг 00 минут г.м]</i>
ТОӨЗ 34.1	Захиалагч гэрээнд заасан бараа, үйлчилгээний тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <i>[10 хувиас ихгүй байх]</i> Захиалагч гэрээнд заасан бараа, үйлчилгээний тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <i>[10 хувиас ихгүй байх]</i>
ТОӨЗ 37.1	Гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <i>[“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож оруул].</i> <i>“Тийм” бол тендерийн баримт бичигт заасан маягтын дагуу ирүүлнэ.</i>
ТОӨЗ 38.2	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <i>[“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож оруул].</i> <i>“Тийм” бол тендерийн баримт бичигт заасан маягтын дагуу ирүүлнэ.</i> Урьдчилгаа төлбөрийн дүн: <i>[Мөнгөн дүнг оруулна.]</i>
ТОӨЗ 39.1	Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: <i>[“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож оруул].</i>

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэр]**, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн **[бараа болон үйлчилгээний нэр]**-г **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]**⁴ төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа, үйлчилгээний хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан бараа, үйлчилгээг гэрээ байгуулснаас хойш **[тоо]** хоногийн дотор нийлүүлж үйлчилгээ үзүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан хуваарьт үндэслэнэ.
3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт **[“үзүүлнэ” эсхүл “үзүүлэхгүй” гэдгийн аль нэгийг оруулах]** **[Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул]** үзүүлнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Бид, захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг, гэрээний нөхцөл шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрч тендерт оролцож байна.
7. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
8. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

⁴ Үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнийг бичнэ.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

[ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР]-Д

Мэдэгдэл хүргүүлэх тухай

- I. Манай компани танай байгууллагаас зарласан **[бараа болон үйлчилгээний нэр]** тендер шалгаруулалтад оролцож байгаа бөгөөд тендерийн баримт бичгийн тендерт оролцогчид өгөх зааварчилгааны 4.2-т заасан дараах нөхцөл байдал үүсээгүй болохыг мэдэгдэж байна. Үүнд:
- 4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
 - 4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
 - 4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;
 - 4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь өөрөө болон толгой компани, эсхүл аливаа салбар нэгж нь санал болгож буй бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
 - 4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон
 - 4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч/эзэмшигч нь нэг этгээд.
- II. Мөн манай компанийн талаар эрх бүхий байгууллагаас /татвар, шүүх, банк.../ тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүйг үүгээр мэдэгдэж байна.

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

ҮНИЙН ХУВААРЬ

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэх хувь	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9)
Тендерийн нийт үнэ (10)									

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг, тамга _____ Огноо _____

БАРААНЫ ЖАГСААЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Бараа/үйлчилгээний тодорхойлолт	Тоо ширхэг/ үзүүлэлт	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан эцсийн цэг	Бараа нийлүүлэх / үйлчилгээ үзүүлэх хугацаа	
					Санал болгож буй хамгийн эхний хугацаа	Санал болгож буй эцсийн хугацаа
1	2	3	4	5	6	7
[Дугаар бичих]	[Товч тодорхойлолтыг бичих]	[Нэгжийн тоо хэмжээг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх, үйлчилгээ үзүүлэх газрын нэр]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хугацааг бичих]

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө. Үйлчилгээг гүйцэтгэж дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцож, нийлүүлэлтийн хугацаатай уялдуулан тогтооно].

1	2	3	4	5	6
Нэр төрөл	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусвал зохих огноо

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

Огноо

Баталгааны дугаар

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа/үйлчилгээний тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн⁵ төлбөр хийх үүрэг хүлээж баталгаа гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

1. Тендерийг нээсний дараа ~~тендерийн маягтад заасан~~ тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерээс ~~ийг буцааж авсан~~, татгалзсан;
2. Захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - 2.1. тендерийн баримт бичигт заасны дагуу ~~тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны~~ гэрээг байгуулаагүй бол;
 - 2.2. тендерийн баримт бичигт заасны тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - 2.3. тендерийн баримт бичигт заасны ~~тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны~~ дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.
3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ. Төлбөр төлөх шаардлагын хэмжээ нь дээр заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба (3)-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг байна.

Энэхүү баталгаа нь [огноог оруул]⁶ өдрийг дуустал буюу захиалагч байгууллагаас ирүүлсэн баталгаа цуцлах хүсэлт хүргүүлэх хүртэл хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банканд мэдэгдэх ёстой.

⁵ Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, ~~үсгээр~~ болон тоогоор заана. Баталгааны мөнгөн дүн нь ТШӨХ-ийн 21.1-д заасантай ижил байна.

⁶ Огноог оруулахдаа ТШӨХ-ийн 21.1-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна. /Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын хувьд уг хугацааг гэрээ байгуултал байхаар тусгах/

Тендерийн баталгааг захиалагчийн зөвшөөрөлгүй цуцалснаас үүдэн гарах эрсдэлийг банк хариуцна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БАТАЛГАА)

Огноо

Баталгааны дугаар

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа/үйлчилгээний тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Хөрөнгийн биржийн нэр] (цаашид “Бирж” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн⁷ төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчийн Засгийн газрын бондыг⁸ үндэслэн баталгаа гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

1. Тендерийг нээсний дараа ~~тендерийн маягтад заасан~~ тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерээс ~~ийг буцааж авсан~~, татгалзсан;
2. Захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - 2.1. ~~тендерийн баримт бичигт заасны дагуу тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны гэрээг байгуулаагүй бол;~~
 - 2.2. ~~тендерийн баримт бичигт заасны тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;~~
 - 2.3. ~~тендерийн баримт бичигт заасны тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.~~
3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ. Төлбөр төлөх шаардлагын хэмжээ нь дээр заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба (3)-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг байна.

⁷ Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дүн нь ТООЗ-ны 21.1-д заасантай ижил байна.

⁸ Засгийн газрын бондын эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

¹¹ Огноог оруулахдаа ТООЗ-ны 21.3-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна. /Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын хувьд уг хугацааг гэрээ байгуултал байхаар тусгах/

Энэхүү баталгаа нь **[огноог оруул]**⁹ өдрийг дуустал буюу захиалагч байгууллагаас ирүүлсэн баталгаа цуцлах хүсэлт хүргүүлэх хүртэл хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.

Тендерийн баталгааг захиалагчийн зөвшөөрөлгүй цуцалснаас үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Биржийнтамга

Огноо:

Хаяг:

⁹ Огноог оруулахдаа ТШӨХ-ийн 21.1-т заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байхаар тооцож оруулна. /Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын хувьд уг хугацааг гэрээ байгуултал байхаар тусгах/

**ҮЙЛДВЭРЛЭГЧ / ГЭРЭЭТ БОРЛУУЛАГЧ / НИЙЛҮҮЛЭГЧИЙН
АЛБАН ЁСНЫ ЗӨВШӨӨРӨЛ**

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч эсвэл гэрээт борлуулагчаар энэ маягтыг бөглүүлсэн байна. Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч эсвэл гэрээт борлуулагчийн хэвлэмэл хуудсан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна.ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: [.....]

Тендер шалгаруулалтын дугаар: [.....]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Бид, **[үйлдвэрлэгч эсвэл гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]**-д байршилтай **[үйлдвэрлэгч гэрээт борлуулагчийн бүрэн нэр]** нь **[үйлдвэрлэдэг эсвэл борлуулдаг барааны төрөл]**-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг эсвэл борлуулдаг бөгөөд, үүгээр **[оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр]** компанид бидний үйлдвэрлэсэн эсвэл борлуулсан **[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]**, барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааг гэрээнд заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч эсвэл гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Ижил төстэй ажлын талаарх мэдээлэл

Одоо хийж байгаа гэрээт ажлын мэдээллийг хамт ирүүлнэ

Төсөл, арга хэмжээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээний үргэлжлэх хугацаа / хэрэгжиж дуусах хугацаа

(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

[ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН НЭР]

[огноо]

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг бичих санамж

Тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь хэлцэл хийгдсэн гэж үзэх үндэслэл болно. Захиалагч энэхүү гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг зөвхөн шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

[Тендер шалгаруулалтын нэр, дугаар]-ын тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгож буйг үүгээр мэдэгдэж байна.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6 хоногийн дараа **[огноо]-ны өдрийн** дотор **[мөнгөн дүн¹⁰]** төгрөгийн гүйцэтгэлийн баталгааны¹¹ хамт гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг гарын үсэг зурсан гэрээний маягтын хамт дээрх хугацаанд багтаан ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

Захиалагч байгууллагын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

¹⁰ Гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож тусгах.

¹¹ Хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-т заасан бол гүйцэтгэлийн баталгаа заавал шаардана.

(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

[ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН НЭР]

[огноо]

Мэдэгдэл хүргүүлэх тухай

[Тендер шалгаруулалтын нэр, дугаар]-ын тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт заасны дагуу дараах шаардлагыг хангаагүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

№	Захиалагчийн тавьсан шаардлага	Тендерт оролцогчийн санал	Шалгараагүй тухай тайлбар
1			
2			
...			

Хүндэтгэсэн,

Захиалагч байгууллагын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь **[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

[Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, төгрөг] [дүн үсгээр, төгрөг]**¹² –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **[баталгааны дүн тоогоор, төгрөг] [дүн үсгээр, төгрөг]**-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэй байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

¹² Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга

Огноо:

Хаяг:

УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот **[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]** гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж **[Захиалагчийн нэр]**-ийн өмнө хариуцлага хүлээж **[Баталгааны мөнгөн дүн][үсгээр]**¹³-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

[Банк нэр] (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, валют][дүн үсгээр, валют]**¹⁴–ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэлхүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

¹³ Энэ дүнг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

¹⁴ Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Техникийн тодорхойлолт болон бусад шаардлага

Техникийн тодорхойлолт болон үйлчилгээний тодорхойлолт бэлтгэх санамж

Энэхүү санамж нь захиалагчид мэдээлэл өгч туслах зорилготой бөгөөд түүнийг тендерийн баримт бичгийг боловсруулж дуусахад хасна.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог.

Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна. Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендерт оролцогчдод өгнө. Үүнд мөн тендерт оролцогч зураг болон загварыг тендертэй хамт, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад захиалагчид урьдчилан хянуулах зорилгоор ирүүлэхээр зааж болно.

Техникийн тодорхойлолт боловсруулахдаа эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх.

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримтыг заавал ирүүлэх ёстой бөгөөд дараах нотлох баримтыг мөн тендерт ирүүлнэ. Үүнд:

- 1.
- 2.

[шаардлагатай баримт бичгүүдийг жагсааж бичих]

Жишиг тодорхойлолт: Эм, эмнэлгийн хэрэгслийн жишиг техникийн тодорхойлолт

Бүтээгдэхүүний болон баглаа боодлын тодорхойлолт

- Тендерийн урилгын дагуу захиалагчийн худалдан авах эм нь эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эмнэлгийн хэрэгсэл нь зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад орсон байна.
- Савлагаа, шошгын стандарт нь ДЭМБ-ийн эм үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хяналтын дүрэм (GMP)-ийн хамгийн сүүлийн шаардлагуудыг бүрэн хангасан байна. Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг нийлүүлэх тендерт оролцогч түүнийг импортлох тусгай зөвшөөрөл авсан байна.
- Бүтээгдэхүүний тодорхойлолтод эмийн хэлбэр /шахмал, тарил/уусмал болон нунтаг, тосон түрхлэг гэх мэт/ болон найрлага, тун хэмжээ /олон улсын нэгж {IU}, мг, процент)-г заана.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл болон түүний савлалт, хаяглалтын материал нь (шил, хуванцар сав гэх мэт) тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Бүх савлагаа нь Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, савлах стандартыг хангаж дахин савлах боломжгүйгээр битүүмжлэгдсэн байна. Захиалагч аливаа нэмэлт шаардлагыг тусгайлан тайлбарласан байна.
- Шошго болон хэрэглэх заавар нь захиалагчийн тусгайлан заасан хэл дээр байна.
- Хөлдөөх эсхүл тодорхой хэмийг тогтвортой байлгах зэрэг хадгалалтын тусгай горим шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн шошго болон сав, баглаа боодолд үүнийг тусгайлан зааж тээвэрлэлтийн явцад мөрдөнө.
- Гэрээ байгуулах эрх авсан этгээд захиалагч шаардсан тохиолдолд тухайн бүтээгдэхүүний тайлбар зааварчилгааг тендерийн хэл дээр хөрвүүлнэ.

Хаяглах заавар

- Эм, эмнэлгийн хэрэгслийн үндсэн савлагаа дээрх шошго нь GMP стандартыг хангасан байх бөгөөд дараах мэдээллийг агуулсан байна:
 - 1) Олон улсын нэр (INN) болон худалдааны нэрийн дээр байнга бичигдэх ерөнхий нэршлийг бичсэн байна. Худалдааны нэр нь ерөнхий нэршлээс илүү тод ба том бичигдэх ёсгүй;
 - 2) Эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);
 - 3) үндсэн үйлчлэгч бодис, түүний нэгж тун дахь хэмжээ;

- 4) зохих фармакопейн стандарт;
- 5) захиалагч шаардлагатай гэж үзвэл захиалагчийн тэмдэг, код, бүртгэлийн дугаар;
- 6) баглаа бүр дэх бүтээгдэхүүний орц хэмжээ;
- 7) хэрэглэх заавар;
- 8) хадгалалтын онцгой нөхцөл /шаардлага;
- 9) цувралын дугаар;
- 10) үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);
- 11) үйлдвэрийн нэр ба хаяг;
- 12) бусад шаардлагатай сануулга.

- Гаднах савлагааны дээр дээрх мэдээллийг мөн тэмдэглэсэн байна.

**Сав, баглаа
боодлын таних
тэмдэг**

- Бүх баглаа боодолд доорх мэдээллийг тусгана:
 - 1) захиалагчийн бүртгэлийн дугаар;
 - 2) эмийн ерөнхий нэршил;
 - 3) эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);
 - 4) үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);
 - 5) цувралын дугаар;
 - 6) нэгж боодол дахь тоо хэмжээ;
 - 7) хадгалалтын тусгай заавар;
 - 8) үйлдвэрийн нэр ба хаяг;
 - 9) бусад шаардлагатай мэдээлэл.
- Боодол бүр нь нэгээс илүүгүй бүтээгдэхүүний цувралыг агуулсан байна.

**Онцлог таних
тэмдэг**

- Захиалагч нь нийлүүлж буй бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаягт өөрийн таних тэмдгийг тусгуулах шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгах замаар нийлүүлэгчид тавьж болно. Түүний загвар болон дэлгэрэнгүй тайлбарыг захиалагч тендер шалгаруулалтын өмнө бэлэн болгосон байх бөгөөд гэрээ байгуулах эрх олгох үед эцэслэн баталгаажуулж нийлүүлэгчид өгнө.

**Барааны
чанарын
баталгааны
стандарт**

- Шалгарсан тендерт оролцогч шаардсан тохиолдолд захиалагчид дараах мэдээлэл, баримт бичгийг ирүүлнэ:
 - 1) нийлүүлэгдэж буй бараанд хамаарах эмийн нэр төрөл бүрийн тоо хэмжээ, химийн шинжилгээ, ариун чанар, халууруулах чанар, хоруу чанарын болон бусад шинжилгээний талаар ДЭМБ-ын жишиг цувралын болон бүтээгдэхүүний сертификат;
 - 2) аль нэг эсхүл бүх шинжилгээний аргачлал (GMP эсхүл ISO);
 - 3) аль нэгэн онцгойлсон эмийн био-хүртээмж болон/эсхүл био-эквивалентын нотолгоо; *Энэ мэдээллийг зөвхөн хатуу нууцлалын доор ирүүлнэ.*
 - 4) худалдаанд зориулсан савлалттай холбогдуулж хүчинтэй байх хугацаа дуусах огноо болон тогтвортой чанарыг илэрхийлсэн бусад үзүүлэлтийг тодорхойлсон үндэслэл;
 - 5) барааны дээж.
- Шалгарсан тендерт оролцогч нь захиалагч шаардсан тохиолдолд үйлдвэрлэлт нь GMP-ийн хадгалалтын шаардлагууд болон чанарын хяналтын механизмд нийцэж буй эсэхтэй танилцуулах зорилгоор түүнийг үйлдвэрлэлийн болон агуулахын байранд нэвтрэх боломжоор хангана.

Эм, эмнэлгийн хэрэгслийг багцлах санамж

Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааны хувьд салбарын онцлог шинж чанараас шалтгаалан зөвхөн бүтээгдэхүүний нэр төрөлд үндэслэсэн стандарт ангиллыг ашиглаж бүтээгдэхүүний багцыг өрсөлдөөнийг хангахуйцаар оновчтой тодорхойлоход хүндрэлтэй байдаг.

Тиймээс эмүүдийг фармакологийн буюу өвчний ангиллаар, эмнэлгийн хэрэгслийг тухайн бараа хэрэглэгдэх нарийн мэргэжлийн тусламжийн төрлөөр багцалж болно. Мөн ижил нэр төрлийн бүтээгдэхүүнийг тэдгээрийг хадгалах хугацаа, хэрэглэх хэмжээ зэргийг сайтар харгалзан багцалж болно. Зайлшгүй шаардлагатай эм худалдан авах ажиллагаанд ашиглаж болох багцын загварыг хавсралтад үзүүллээ. Багц нь аль болох жижиг байх нь зохимжтой.

Эмнэлгийн хэрэгслийг багцлахдаа Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг үндэслэн дараах ангиллыг ашиглана. Үүнд:

- 1) Ороох боох материал
- 2) Тариур зүү, мэс заслын хутга
- 3) Оёдлын материал
- 4) Хамгаалалтын хувцас
- 5) Катетер, гуурс
- 6) Рентген
- 7) Унтуулгын хэрэгсэл
- 8) Хэт авианы хэрэгсэл
- 9) Шүд, эрүү нүүрний хэрэгсэл
- 10) Нүдний хэрэгсэл
- 11) Чих хамар хоолойн хэрэгсэл
- 12) Уламжлалт анагаах ухаан
- 13) Эх барих, эмэгтэйчүүдийн хэрэгсэл
- 14) Бусад.

Нэг төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг илэрхийлэхэд олон тооны худалдааны нэр болон барааны тэмдгүүд хэрэглэгддэг учир тендер шалгаруулалтын багцыг хийхдээ тухайн эмийн олон улсын нэршлийг ашиглах нь зүйтэй.

Энэ нь мөн өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Тендерт оролцогч нь техникийн тодорхойлолтыг хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг худалдааны нэрээр ирүүлж шалгарсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчоос худалдааны нэрийн дээд талд том үсгээр, илүү тодоор олон улсын нэршил буюу ерөнхий нэрийг бүх хаяглалт дээр харуулахыг шаардах хэрэгтэй.

Үйлчилгээний тодорхойлолт

Үзүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил бүрийг дуусгахаар төлөвлөсөн хугацаа, тэдгээр ажлыг гүйцэтгэх байршил, захиалагчийн баталж хийлгэх тусгай ажлууд гэх мэтээр үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, танилцуулгыг бичих.

Төлбөр хийх бүх үе шатууд, үзүүлэх үйлчилгээний эсхүл гаргах тайлангийн хэлбэр, давтамж болон агуулга, тэдгээрийг хүлээж авах хүмүүс, ирүүлэх хугацаа гэх мэтийг жагсааж бичнэ.

Үйлчилгээг аль болох хүрэх үр дүн, үйл ажиллагаа, гүйцэтгэлийн чанарын талаас нь тодорхойлж бичих

БАРААНЫ ЖАГСААЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө.]

Нэр	Бараа/үйлчилгээний тодорхойлолт	Тоо ширхэг/ үзүүлэлт	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан эцсийн цэг	Бараа нийлүүлэх/үйлчилгээ үзүүлэх хугацаа	
					Хамгийн эхний хугацаа	Эцсийн хугацаа
1	2	3	4	5	6	7
[Дугаар бичих]	[Товч тодорхойлолтыг бичих]	[Нэгжийн тоо хэмжээг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх, үйлчилгээ үзүүлэх газрын нэр]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хугацааг бичих]

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ

[Энэхүү хүснэгтийг захиалагч бөглөнө. Үйлчилгээг гүйцэтгэж дуусах хугацааг аль болох бодитой байхаар тооцож, нийлүүлэлтийн хугацаатай уялдуулан тогтооно].

1	2	3	4	5	6
Нэр төрөл	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үйлчилгээг гүйцэтгэх газар болон ажлын талбай	Үйлчилгээг гүйцэтгэж дуусвал зохих огноо

